

**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох
итгэлцүүр хэрэглэх журам”-ыг шинэчлэн батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос гаргасан даатгалын багц дүрмийн хүрээнд мөрдөгдөнө.

Хоёр. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох, итгэлцүүр хэрэглэх

2.1. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан суурь хураамж, мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасан итгэлцүүрийг хэрэглэх ба даатгалын суурь хураамжийг дараах итгэлцүүрүүдээр нэмэгдүүлэн буюу хорогдуулан тооцно. Үүнд:

2.1.1. тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүр /цаашид И₁ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.2. өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдол /зам тээврийн ослын зөрчил/-ын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр /цаашид И₂ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.3. даатгуулагчийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах итгэлцүүр /цаашид И₃ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.4. даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр /цаашид И₄ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.5. даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн эсэхээс хамаарах итгэлцүүр /цаашид И₅ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.6. тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тооноос хамаарах итгэлцүүр /цаашид И₆ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.7. тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах итгэлцүүр /цаашид И₇ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.8. тээврийн хэрэгслийн зориулалт ба тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангасан эсэхээс хамаарах итгэлцүүр /цаашид И₈ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 8 дугаар хавсралтад заасны дагуу тооцно ;

2.1.9. чиргүүлтэй эсэхээс хамаарах итгэлцүүр /цаашид И₉ итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 8 дугаар хавсралтад заасны дагуу тооцно.

2.2. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцохдоо дараах хүснэгтийг ашиглах ба Х₀ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан суурь хураамж байна.

	Даатгалын хураамжийн төрөл	Даатгалын хураамжийг тооцох томьёо
1	Мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн даатгалын хураамж	$X = X_0xI_2xI_3xI_4xI_5$
2	Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн даатгалын хураамж	$X = X_0xI_1xI_2xI_3xI_4xI_5xI_6xI_7xI_8xI_9$
3	Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0xI_1xI_2xI_4xI_5xI_6xI_7xI_8xI_9$
4	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0xI_1xI_2xI_3xI_4xI_5xI_6xI_7xI_8xI_9$

Гурав. Хяналт, хариуцлага

4.1.Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

И₁ итгэлцүүрийг тогтоох

1. И₁ итгэлцүүрийг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд бичигдсэн газар нутгийн байршлыг үндэслэх ба дараах хэмжээтэй байна.

№	Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил	И ₁
1	Улаанбаатар хот	1.3
2	Дархан-Уул	1.1
3	Дорноговь	1.1
4	Дорнод	1.1
5	Орхон	1.1
6	Өмнөговь	1.1
7	Төв	1.1
8	Хэнтий	1.1
9	Сэлэнгэ	1.1
10	Ховд	1.1
11	Баян-Өлгий	1
12	Булган	1
13	Говь-Алтай	1
14	Говьсүмэр	1
15	Дундговь	1
16	Завхан	1
17	Өвөрхангай	1
18	Сүхбаатар	1
19	Архангай	1
20	Увс	1
21	Хөвсгөл	1
22	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгсэл	1.5

“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын 2 дугаар хавсралт

И₂ итгэлцүүрийг тогтоох

1. И₂ итгэлцүүрийг энэ журмын дараах хүснэгтэд үндэслэн тогтоох бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйн улмаас даатгалын тохиолдлыг бий болгосон нөхцөлд энэ журмын 2 дугаар хавсралтын 2-т заасан хэмжээгээр нэмэгдүүлэн тогтооно:

Даатгуулагчийн 1 өмнөх 365 хоногийн И ₂ -ийн утга	Өмнөх 365 хоногийн даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр И ₂												
	Нөхөн төлбөр олгоогүй	1 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/				2 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/				3 болон түүнээс дээш удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/			
		300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш	300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш	300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш
2.45	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
2.3	1.55	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.55	1.4	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.4	1	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1	0.95	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.95	0.9	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.9	0.85	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.85	0.8	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.8	0.75	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.75	0.7	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45
0.7	0.65	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45
0.65	0.6	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45
0.6	0.55	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45
0.55	0.5	0.6	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3
0.5	0.5	0.55	0.6	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55

2. Даатгалын гэрээ эзэмшигч нь хуулийн этгээд /Банк болон Банк бус санхүүгийн байгууллын барьцаалбар хэлбэрээс бусад/ байх тохиолдолд И₂ итгэлцүүрийн хэмжээг тогтоохдоо дээрх хүснэгтэд үндэслэхээс гадна тухайн хуулийн этгээдийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүд нь 1 жилд 3-аас дээш даатгалын тохиолдол гаргасан бол И₂ итгэлцүүрийн утгыг 2.45-аар нэмэгдүүлэн тооцно.

3. Даатгалын гэрээ эзэмшигч нь хуулийн этгээд нь Банк болон Банк бус санхүүгийн байгууллын барьцаалбар хэлбэрээр байх тохиолдолд И₂ итгэлцүүрийн хэмжээг тогтоохдоо автотээврийн хэрэгслийн үндсэн эзэмшигчийн И₂ итгэлцүүрийн утгыг хэрэглэнэ.

4. Монгол улсын хууль тогтоомжид заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын дараах дүрмийг зөрчин даатгалын тохиолдол гаргасан бол энэ журмын 3.2-т заасан И₂ итгэлцүүрийг И₂ + 0.4 гэж тооцно.

4.1. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргасан ;

4.2. замын хөдөлгөөний хурдны хязгаарлалтыг хэтрүүлсэний улмаас зам тээврийн осол гаргасан ;

4.3 замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, зохицуулагчийн зааврыг зөрчин зам тээврийн осол гаргасан ;

4.4. замын хөдөлгөөний дүрэмд хориглосон нөхцөлөөр жолооч урсгал сөрсөн үедээ зам тээврийн осол гаргасан.

5. энэ журмын 2 хавсралтын 2 болон 4 дэх хэсэгт заасан итгэлцүүрийн утгыг нэмэгдүүлэх заалтыг дараа жилийн гэрээний хугацаанд 1 удаа хэрэглэнэ.

6. даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээг өссөн дүнгээр тооцох ба даатгуулагчийн 1 жилийн өмнөх I_2 итгэлцүүрийг тухайн гэрээ байгуулж буй хугацаанаас 1 жилийн өмнөх эсхүл 1 жилийн өмнөх хугацаанаас өмнө хамгийн ойр хугацааны I_2 итгэлцүүрээр тогтооно.

7. I_2 итгэлцүүрийг жолоочийн даатгалын гэрээ байгуулахад даатгуулагчийн 1 өмнөх I_2 итгэлцүүрийн утга болон өмнөх 1 жилийн даатгуулагчийн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнд үндэслэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангаагүйн улмаас даатгалын тохиолдлыг бий болгосон зэргээс хамааруулж тогтоох ба жолоочийн даатгалын гэрээ анх байгуулж байгаа тээврийн хэрэгслийн өмчлөгч, жолоочийн I_2 итгэлцүүрийн утга $I_2=1$ байна.

8. даатгалын тохиолдол, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ, зам тээврийн ослын зөрчлийг бүртгэхдээ тээврийн хэрэгслийг жолоодож явсан жолоочийн түүх болон тээврийн хэрэгслийн өмчлөгчийн түүх дээр бүртгэнэ.

--ooOoo--

И3 итгэлцүүрийг тогтоох

1. И3 итгэлцүүрийг дараах хүснэгтэд үндэслэн тогтооно:

Туршлага		25 хүртэлх насны	26-40 хүртэлх насны	41-60 хүртэлх насны	61 болон түүнээс дээш насны
Даатгуулагчийн нас					
5 хүртэл удаа даатгалын гэрээ байгуулсан	5 жил хүртэлх туршлагатай	1.4	1.35	1.25	1.3
	5 -10 жил хүртэлх туршлагатай	1.35	1.25	1.15	1.25
	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1.15	1.15	1.2
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1.1	1.1	1.15
6-10 хүртэл удаа даатгалын гэрээ байгуулсан	6 -10 жил хүртэлх туршлагатай	1.2	1.15	1.1	1.2
	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1.1	1	1.15
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1.05	1	1.1
10-с дээш удаа даатгалын гэрээ байгуулсан	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1	0.95	1.05
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1	0.9	1.05

2. Даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд И₃=1.4 байна.

3. даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийг хэд хэдэн жолооч ашиглах бол тэдгээрийн хамгийн өндөр итгэлцүүрийг И₃ гэж тооцно.

4. тээврийн хэрэгслийн өмчлөгч нь хуулийн этгээд бол И₃=1.5 байна.

И₄ итгэлцүүрийг тогтоох

1. Монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа /1 жил/-аас хамаарах итгэлцүүр И₄=1 хэмжээтэй байна.

2. гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр И₄ нь дараах хэмжээтэй байна:

Гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа	И ₄
2 сар хүртэл	1.3
2 сараас 3 сар хүртэл	1.6
3 сараас 4 сар хүртэл	1.9
4 сараас 5 сар хүртэл	2.1
5 сараас 6 сар хүртэл	2.4

И₅ итгэлцүүрийг тогтоох

1. Даатгуулагч даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн нь тогтоогдвол тус даатгалын гэрээ дууссаны дараа байгуулсан гэрээний даатгалын хураамжийг $I_5=1.3$ итгэлцүүрээр нэмэгдүүлж тооцно.

--ooOoo--

И₆ итгэлцүүрийг тогтоох

1.И₆ итгэлцүүр нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгсэл ашиглах жолоочийн тоог хязгаарласан эсэх	И ₆
Хувь хүний нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Зөвхөн тээврийн хэрэгслийн өмчлөгч даатгуулсан буюу даатгалын гэрээнд 1 жолоочийн дурдсан	1.0
Гэр бүлийн хүрээнд буюу даатгалын гэрээнд 2-4 жолоочийн нэр дурдсан	1.1
Даатгалын гэрээнд 4-с дээш жолоочийн нэр дурдсан	1.3
Даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.3
Хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Банк, ББСБ болон санхүүгийн байгууллагын барьцаанд буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд 1-4 жолоочийн нэр дурдсан	1.3
Банк, ББСБ болон санхүүгийн байгууллагын барьцаанд буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.3
Нийтийн зорчигч, тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд 1-3 жолоочийн нэр дурдсан	1.8
Нийтийн зорчигч, тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.45
Бусад хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	1.8

И7 итгэлцүүрийг тогтоох

1. И7 итгэлцүүр нь тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал зэргээс хамааран дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		И7
<p>В ангилал Хөдөлгүүрийн багтаамж /см³/</p>	-1000 хүртэл	0.9
	-1001-2000	1.0
	-2001-3000	1.1
	-3001-4000	1.2
	-4001-с дээш	1.3
<p>С ангилал Тээврийн хэрэгслийн даац</p>	-8 тонн хүртэлх даацтай	1.0
	-8 болон түүнээс дээш тоннын даацтай	1.3
<p>Д ангилал Суудлын тоо</p>	-16 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	1.3
Байгаль орчинд ээлтэй цахилгаан болон бусад тусгайлсан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл	Бүх ангиллын тээврийн хэрэгсэл ба хөдөлгүүрийн чадал үл хамаарна	0.8

2. И7 нь тээврийн хэрэгслийн ашиглалтын төрөл зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг авсан байдал болон тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлаас хамааран дараах байдлаар тооцно:

№	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал	төрөл	И7
1	Үйлдвэрлэгдсэн он	2010 болон түүнээс өмнөх он	1.3
		2011-2015 хүртэлх он	1.2
		2016-2020 хүртэлх он	1.1
		2021 он болон түүнээс хойших	1
2	Жолооны хүрдний байрлал	Баруун	1.1
		Зүүн	1
3	Өмнөх жилд туулсан замын урт	1-5000 хүртэлх км	1
		5001-10000 хүртэлх км	1.1
		10001 болон түүнээс дээш км	1.2
4	Хар хайрцагтай эсэх	Тийм	0.8
		Үгүй	1
5	Телематик болон үүнтэй адил тоног, төхөөрөмжтэй эсэх	Тийм	0.8
		Үгүй	1
6		Тийм	0.9

Ухрах камер, аюул ойртох үеийг мэдрэх төхөөрөмжтэй эсэх	Үгүй	1
---	------	---

3. И₇ итгэлцүүрийг тооцохдоо энэ журмын 7 дугаар хавсралтын 1-т заасан хэмжээг 2-т заасан хамаарал бүрийн дундаж утгаар үржүүлж тооцно.

4. гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах итгэлцүүр И₇ дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		И ₇
<u>В ангилал</u> Хөдөлгүүрийн багтаамж /см ³ /	-1000 хүртэл	1.0
	-1001-2000	1.3
	-2001-3000	1.6
	-3001-4000	1.9
	-4001-с дээш	2.1
<u>С ангилал</u> Тээврийн хэрэгслийн даац	-10 тонн хүртэлх даацтай	1.0
	-10-аас 20 хүртэлх тоннын даацтай	1.5
	-20-иос 40 хүртэлх тоннын даацтай	2.0
	-40 болон түүнээс дээш тоннын даацтай	3.0
<u>Д ангилал</u> Суудлын тоо	-15 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16-аас 33 хүртэлх зорчигчийн суудалтай	2.0
	-33 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	3.0

5.И₇ итгэлцүүрийг тогтоохдоо В, С болон D ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалд энэхүү журмын 2.8.1, 2.8.2-т заасан хүснэгтийг үндэслэнэ.

6.“А” болон “механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд И₇=1 байхаар тооцно.

--ooOoo--

И₈ итгэлцүүрийг тогтоох

1. И₈ итгэлцүүр нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн зориулалт	И ₈
Хувийн	1.0
Хуулийн этгээдийн	
Албан хэрэгцээнд /Банк, ББСБ-ын барьцаанд буй хувийн хэрэгцээний тээврийн хэрэгсэл болон бусад албан хэрэгцээний тээврийн хэрэгсэл/	1.2
Нийтийн тээврийн үйлчилгээ	1.6
Хот дотор түгээлт	1.5
Хот хоорондын түгээлт	1.5
Ачаа, тээвэр	1.5
Хүнд овор ихтэй ачаа, тээврийн	1.8

2. тээврийн хэрэгслийн зориулалтыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд дурдсан өмчлөгчийн мэдээллийг үндэслэнэ.

3. И₉ итгэлцүүр нь дараах хэмжээтэй байна:

Чиргүүлтэй эсэх	И ₉
Чиргүүлгүй	1.0
Чиргүүлтэй	1.2